



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 40.

Есөнбулаг сум

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хоггүй цэвэр- Алтай” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөв, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган батлуулж, биелэлтийн явцыг жил бүрийн IV улиралд багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА



Т.ГАНЗОРИГ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2017 оны 07 дугаар сарын  
24 өдрийн 70 дүгээр тогтоолын хавсралт



## “ХОГГҮЙ ЦЭВЭР-АЛТАЙ” ДЭД ХӨТӨЛБӨР

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

#### 1.1. Нийтлэг үндэслэл

Хот суурин газруудын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний төвлөрөл ихэсч, орчны бохирдлын эх үүсвэр нэмэгдсээр байгаагийн дотор амьдралын нөхцөлийг доройтуулж, орчныг бохирдуулж буй гол хүчин зүйлийн нэг нь хог хаягдал болоод байна. Харин энэ хог хаягдлын асуудлыг бодлогын хэмжээнд авч үзэж, хог хаягдлыг бууруулах, эргүүлэн ашиглах, боловсруулах арга хэмжээ авч, хог хаягдлын гаралтыг багасгаж, байгаль орчныг бохирдолтоос сэргийлэх, элдэв хортой нөлөөллөөс хүн амын эрүүл мэндийг хамгаалах асуудал өнөө үед тулгамдаад байна.

Аймгийн хэмжээнд хог хаягдлын нэгдсэн менежментийн тогтолцоо төлөвшөөгүй, хатуу хог хаягдлыг ил задгай хаядаг, тогтмол хугацаанд татан зайлуулдаггүй, зөвхөн газарт дарж булах аргаар устгадаг, аюултай хог хаягдлыг устгах зориулалтын байгууламж байхгүй, хог хаягдлын цэгүүд эрүүл ахуйн шаардлага хангахгүй байгаа зэрэг олон тулгамдсан асуудлууд байна.

Иймд хог хаягдлын менежментийг шинэ шатанд гаргаж, хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах, бохирдуулагч нь төлбөр төлөх, 3R (бууруулах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах) зарчимд тулгуурлан иргэдийн сэтгэлгээг өөрчилж, ухамсрыг дээшлүүлэх, хог хаягдлыг зайлуулах арга хэмжээг сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, бэхжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг өндөржүүлж, бүх нийтийн оролцоотойгоор хог хаягдлыг бууруулж, цэвэр эрүүл орчинг бүрдүүлэх чиглэлээр зорилго, зорилт, үйл ажиллагааг тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

“Хоггүй цэвэр- Алтай” дэд хөтөлбөр нь аймгийн хэмжээнд хог хаягдлын зохистой менежментийг бий болгох, хог хаягдлыг бууруулах талаар 2017-2020 онд хэрэгжүүлэх ажлын чиглэл, арга замыг тодорхойлсон дунд хугацааны баримт бичиг юм.

#### 1.2. Өнөөгийн нөхцөл байдал

**1.2.1. Газарзүйн байршил:** Говь-Алтай аймаг нь Монгол Улсдаа газар нутгийнхаа хэмжээгээр 2 дугаарт буюу Өмнөговь аймгийн дараа ордог бөгөөд Монгол орны баруун урд хэсэгт орших 141.4 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, хойд талаараа Завхан, зүүн талаараа Баянхонгор, баруун талаараа Ховд аймаг, өмнөд хэсгээрээ БНХАУ-тай тус тус хиллэдэг. Аймгийн төв нь Улаанбаатар хотоос 1001 км алслагдсан, бусад аймгуудын төвөөс хамгийн өндөрт өргөгдсөн бөгөөд далайн түвшнээс дээш 2181м, ойролцоогоор Богд хан уулын оройтой тэнцэхүйц хэмжээний өндөрт оршдог. Бусад бүсээс ялгаатай нь говь, хангай хосолсон өргөн уудам нутагтай далайн түвшнээс дээш 721-4070 метр өндөрт, газар хөдлөлийн идэвхитэй бүсэд оршдог. Дэлхийн

1087

цагийн 6 дугаар бүсэдбайрладаг бөгөөд уул, тал,хөндий, уужимговь, тавиун хотгор, хонхор хосолсонгазрын гадаргуутай.Аймгийн нутаг дэвсгэр нь газрын дүрс мужлалын хувьд алтайн уулархаг их муж, говийн их мужид хамаарах бөгөөд байгалийн бүсбүслүүрийн хувьд гол төлөв говь, цөлийн бүсэдь оршино.Мөн бага хэмжээгээр хээр тал болон өндөр уулсын босоо буюу тагийн бүслүүр тархсанбайдаг. Засаг захиргааны 18 сум, 87 багтай.

**1.2.2.Уур амьсгал:** Эх газрын эрс тэс уур амьсгалтай учир цаг агаарын гамшигт үзэгдэл тохиолдох нь элбэг, эдийн засаг нь байгаль, цаг уурын нөхцөлөөс хараат байдаг. Тус аймагт өндөр уулын, тал хээрийн, цөлөрхөг говь хээрийн уур амьсгал зонхилно. Бас чийглэгдүү хүйтэн, тагийн болон дулаан говь цөлийн уур амьсгал хагас цөл нутаг хийгээд өндөр уулын хормойн хэсэгт бүрэлджээ. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд дунджилсан агаарын олон жилийн дундаж температур 1.08°C байна. Харин аймгийн хур тунадасны хувьд жилд дунджаар Алтайн нурууны салбар уулс, Сутай,Хантайшир,Гичгэний нуруугаар 120-250 мм, Хүйс, Шарга, Бигэрийн говь хоолой болон Алтайн өвөр говиор 40-120 мм орчим тунадас унадаг бөгөөд жилийн нийт хур тунадасны 85 орчим хувь нь дулааны улиралд буюу 4-9-р сар түүнээс зөвхөн 6-8-р сард 66.2 хувь нь ордог байна. Жилийн дундаж салхины хурд 2-5м/с хурдэг бөгөөд шороон шуурга ууландаа жилд дунджаар 35-37, говьд 56-59 өдөр шуурдаг.

**1.2.3.Хүн ам:** Тус аймагт 16.3 мянган өрхөд 56.7 мянган хүн амьдарч байгаагаас 5053 өрх аймгийн төвд, 306 өрх тосгонд, 3900 өрх сумын төвд, 6995 өрх хөдөө амьдарч байна. Аймгийн нийт хүн амын 30.2 хувь буюу 17.1 мянга нь аймгийн төвд, 25.2 хувь буюу 14.3 мйнга нь сумын төвд, 43 хувь буюу 24.4 хувь нь хөдөө, 1.6 хувь буюу 0.9 мянга нь тосгонд амьдарчбайна. Хүн амын жилийн дундаж өсөлт 1,0 хувьтай, дундаж наслалт 67.87 байна.

**1.2.4.Боловсролын салбар:** Сургуулийн өмнөх боловсролын 28 цэцэрлэгийн 139 бүлэгт 4538 хүүхэд хүмүүжиж байгаагаас 3498 нь цэцэрлэгийн ангид, 1040 нь хувилбарт сургалтаар суралцаж байна. Тус салбарт 484 хүн ажиллаж байгаа бөгөөд 28 цэцэрлэгээс стандартын 22, стандартын бус 8 цэцэрлэгийн барилга 2410 орны хүчин чадалтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

2015-2016 оны хичээлийн жилд төрийн 27, хувийн өмчийн 1 нийт 28 сургуульд өдрийн ангийн 481 бүлэгт 11430, эчнээгээр 110, дүйцсэн хөтөлбөрөөр 508, нийт 12048 суралцагч суралцаж байна.

Баруун бүс нутгийг эмч, эмнэлгийн мэргэжилтнээр хангах зорилготой Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль /АШУҮИС/-ийн аймаг дахь салбар сургуульд 2015-2016 оны хичээлийн жилд 974 оюутан суралцаж байна.

**1.2.5.Эрүүл мэндийн салбар:** Тус аймагт эрүүл мэндийн салбарт Эрүүл мэндийн газар, аймгийн нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны төв, Зооноз өвчин судлалын төв, сум дундын эмнэлэг 3, сумын эрүүл мэндийн төв-14, тосгоны эрүүл мэндийн төв 2, багийн эмнэлэг 2, өрхийн эрүүл мэндийн төв 3, ортой хувийн эмнэлэг 3, үүдэн эмнэлэг 12, эмийн сан 10, эм ханган нийлүүлэх байгууллага 2, хувийн лаборатори 1, хортон устгах, халдваргүйтгэл, халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж 1, нийт 57 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Эрүүл мэндийн салбарт 172 их эмч, 20 эм зүйч, сувилагч бага эмч, эм найруулагч, бусад дунд мэргэжилтэн 505, бусад дээд мэргэжилтэн 58, бусад ажиллагсад 301, нийт 1076 хүн ажиллаж байна.



**1.2.6. Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн салбар:** Мал аж ахуйн салбарт 2016 оны жилийн эцсийн мал тооллогоор 3497.5 мянган толгой мал тоологдсоноос адуу 106.8 мянга, үхэр 71.1 мянга, тэмээ 38.5 мянга, хонь 1107.1 мянга, ямаа 2173.9 мянган толгой мал тус тус тоологдсон байна. Энэ нь өмнөх оноос адуу 20.8 хувиар, үхэр 20.9 хувиар, тэмээ 1.1 хувиар, хонь 21.8 хувиар, ямаа 18.7 хувиар өссөн дүнтэй байна.

Малтай 9932 өрх байгаагийн 6903 нь малчин өрх байна. Малчин өрхөөс цахилгааны эх үүсвэртэй өрх 6.1 мянга, сансрын антентай өрх 5.0 мянга, телевизортой өрх 5.3 мянга, радиотой өрх 2.6 мянга, гар утастай өрх 5.8 мянга байна.

Тус аймагт 17 усралтын системийг түшиглэн газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэдэг бөгөөд нийтдээ 4230 га талбайг ашиглах боломжтойгоос, 2016 онд үр тариа 525.3 тн, төмс 633.1 тн, хүнсний бусад ногоо 468.8 тн, малын тэжээлийн ургамал 1479 тн-г тус тус хураасан байна. Мөн 5169.3 тн байгалийн хадлан, 283.2 тн гар тэжээл, 2879.5 тн хужир шүү тус тус бэлтгэсэн.

Манай аймагт Мандал-Хүдэр, Алтай-Улиастай Эрчим хүчний үйлдвэр, Тулга-Алтай, Ентүм, Ундарга-Эх, Ундррам-Оюу, Баярт-Олон, Залуур-Алтай, Залуур-Өргөө, Оюу-Бейкери, Хүслийннаран зэрэг аж ахуйн нэгж 58, хувиараа аж ахуй эрхэлдэг 206 хувь хүмүүс үйлдвэрлэл эрхэлж байна. Дээрх иргэн, аж ахуйн нэгжүүд нь цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэл, нүүр болон хүдэр олборлолт, гутал хувцас, архи дарс, ус, ундаа жүүс, талх нарийн боов, хиаман төрлийн бүтээгдэхүүн, банш бууз, сүү, сүүн бүтээгдэхүүн, арвайн гурил, хуванцар цонх, хаалт, тоосго, блок зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.

**1.2.7. Дэд бүтэц:** АУЭХС ТӨХК-ий цахилгаан дамжуулах сүлжээ ББЭХС систем, Есөнбулаг эрчим хүч дизель цахилгаан станц, Тайшир Гуулин УЦС нь зундаа 5,6 мв, өвөлдөө 12,6 мв хүчин чадалтай эх үүсвэрээр тус аймаг болон завхан аймгийн төв бүх сумдын нийт 20000 гаруй өрх, аж ахуйн нэгжийг цахилгаан эрчим хүчээр хангаж байна.

Алтай сум Баянтоорой тосгоны 500 орчим өрх айл, 62 аж ахуй нэгж байгууллагыг сэргээгдэх эрчим хүчийг дизель станцтай хослуулан хоногт 10-16 цаг цахилгаан эрчим хүчээр хангаж байна.

Хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагааг “Аяны зам-Алтай” хоршоо, “Бид-Анд” ХХК-ий гэрээт жолооч нар Алтай-Улаанбаатар-Алтай чиглэлд өдөр бүр зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлж байна.

Алтай-Ховд чиглэлийн 265 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажил, Алтай - Баянхонгор чиглэлийн 265 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажлаас 126.7 км авто замын ажил хийгдэж байгаа бөгөөд аймгийн төвөөс сумдруу, сумаас сумруу шороон болон сайжруулсан замтай. Аймгийн төвд 13,576 км зам асфальт, бетон хучилттай, шинээр нэмж 5,1 км замыг асфальт, бетоноор хучих шаардлагатай байна.

**1.2.8. Хог хаягдлын менежментийн өнөөгийн байдал:** Аймгийн 18 сум 2 тосгонд ашиглаж байгаа 23, ашиглагдахаа больсон 4 хогийн цэг байна. Хогийн цэгүүд нь төв суурин газраас 1-6,5 км зайтай байрладаг, хог хаягдлын үйлчилгээний хураамж айл өрхөд 500-6000, аж ахуйн нэгжид 1000-10000, байгууллагад 2000-20000 төгрөгний хооронд хэлбэлзэж байна. Хог хаягдлын үйлчилгээний хураамж сумдын татварын орлогод орж, хог тээврийн үйлчилгээг орон нутгийн хөгжлийн сан, төсөл хөтөлбөр болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байна. Аймгийн төвийн хувьд хог тээврийн үйлчилгээг Алтай хотын тохижилт үйлчилгээний

газар хариуцаж, бусад сумд ЗДТГ болон тамгын газартай гэрээ байгуулсан иргэд хариуцан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд аймгийн төвд 1,5 тн даацтай 4, 2,5 тн даацтай 3, бусад сумдад 1-4 тн даацтай 1-2 машин ашиглагдаж, нийт 27 машиныг хог тээвэрт ашиглаж байна. Алтай хотын хог тээврийн үйлчилгээнд жолооч 8, ачигч 5, бусад сумдад ачигч, жолооч 1-2 хүн ажиллаж, айл өрхийн хогийг аймгийн төвд 2-4 сард нэг удаа, бусад сумдад сард 1-2 удаа хогийн цэгт төвлөрүүлж байна. Нийтийн эзэмшлийн гудамж талбайд байрлах хогийн савны тухайд аймгийн төвд хогийн сав 75, бункер 22, бусад сумдад хогийн сав 0-20, бункер 0-8 ширхэг хэмжээтэй байгаа бөгөөд аймгийн хэмжээнд ландфиллийн аргаар тохижуулсан хогийн цэг 1, хур хог хаягдалтай сум 5 байна.

Аюултай хог хаягдлын тусгай цэгтэй сум байхгүй. Бүх сумын хүн эмнэлэг автоклавтай болсон боловч тогны хүчдэл хүрдэггүй учраас автоклав ашигладаггүй, аймгийн төвийн өрхийн эрүүл мэндийн төвүүд болон хувийн эмнэлэгүүд нэгдсэн эмнэлэгтэй хог хаягдлын гэрээтэй ажилладаг.

**1.2.9.Алтай хотын тохижилт үйлчилгээний газар:** Хантайшир хийдийн Артель нэртэйгээр лам нарын хороо, түүний ойролцоо гудамж талбайн хог хаягдлыг цэвэрлэх, тохижуулах чиглэлээр 1938 онд анх суурь нь тавигдаж эхэлсэн түүхтэй. 1940 онд аймаг байгуулагдахад Артель нэртэйгээр үйл ажиллагааныхаа ерөнхий чигийг хадгалж үйл ажиллагаа явуулж байгаад 1986 оноос Алтай хотын захиргааны дэргэдэх хот тохижуулах анги болон өргөжсөн. 2006 оноос “Алтайн жавхлант” ОНӨААТҮГ болж, 2013 оноос Алтай хотын тохижилт үйлчилгээний газар болж нийтийн эзэмшлийн гудамж, талбай, хөшөө дурсгалын цэвэрлэгээ арчилгаа, хамгаалалт, гэрэлтүүлэг, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хотын тохижилт, ногоон байгууламж түүний хайс хамгаалалт, усалгаа арчилгаа, хог тээвэр, хогийн цэгийг хариуцан орон нутгийн төсвөөс санхүүжин ажиллаж байна. Тус газар нь дарга, нягтлан бодогч, аж ахуйн нярав, бичиг хэрэг, хот тохижилт ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн, ногоон байгууламжийн усалгааны жолооч, ландфиллийн мэргэжилтэн, хог тээврийн зохицуулагч, автомеханик тус бүр нэг, сахиул 6, зам талбайн үйлчлэгч 10, орлогын байцаагч 2, ачигч 5, жолооч 8, нийт 39 хүний орон тоотойгоор үйл ажиллагаа явуулдаг. Хог тээврийн үйлчилгээнд 2,5 тн даацтай автомашин 3, 1,5 тн даацтай автомашин 4, ковш 3, түрдэг ухдаг трактор 1, ногоон байгууламжийн усалгаанд 5 тн даацтай автомашин 1-г ашиглаж байна. /Алтай хотын тохижилт үйлчилгээний газар нь өдөрт 40-48 тн хог татан зайлуулдаг/

## ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

**2.1. Зорилго:** Аймгийн хатуу хог хаягдлын зохистой менежментийг төлөвшүүлэх замаар төв суурин газрыг хоггүй цэвэр болгож, иргэдийн амьдрах орчиныг сайжруулахад энэхүү дэд хөтөлбөрийн гол зорилго оршино.

**2.2. Зорилт:** Тус дэд хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.2.1. Хог хаягдлын удирдлага, зохион байгуулалт, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно

2.2.2. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, зайлуулах үйл ажиллагааг сайжруулж, хогийн цэгүүдийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн тохижуулах цогц арга хэмжээ авна

2.2.3. Хог хаягдлыг дахин боловсруулж, хоёрдогч бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар хог хаягдлын хэмжээг бууруулна

2.2.4. Аюултай хог хаягдлыг байгаль орчинд хал багатайгаар зайлуулж, аюултай хаягдал хуримтлагдахаас сэргийлнэ

2.2.5. Эзэнгүй хог хаягдлын хэмжээг бууруулна

2.2.6. Хүн амд ногоон хэрэглээний соёл, амьдрах орчны эрүүл ахуйн зөв дадлыг төлөвшүүлэх арга хэмжээ авна

### **ГУРАВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

**3.1. Удирдлага, зохион байгуулалт:** Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлагаар аймгийн Засаг дарга хангаж, хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээллээр хангах, шаадрлагатай судалгаа, шинжилгээний ажлыг хийлгэх, хяналт тавих, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах үүргийг аймгийн хэмжээнд Засаг даргын тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Зооноз өвчин судлалын төв болон бусад холбогдох байгууллагууд хүлээж, сумын түвшинд тухайн шатны Засаг дарга хариуцан ажиллана.

**3.2. Хэрэгжүүлэх хугацаа:** Энэхүү дэд хөтөлбөрийг 2017-2020 он хүртэл хэрэгжүүлнэ.

**3.3. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим:** Тус дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.  
Үүнд:

а/ Байгаль орчныг хамгаалах бусад үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө болон орон нутгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлэх;

б/ Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг өргөнөөр оролцуулах, хамтын ажиллагааг сайжруулах арга хэмжээ авах;

в/ Хүн ам ихээр төвлөрөн суурьшсан төв суурин газрын хог хаягдлыг бууруулахад түлхүү анхаарч, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг бүрэн төвлөрүүлэх;

г/ Хог тээврийн үйл ажиллагааны хүчин чадлыг нэмэгдүүлж, хог тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх;

д/ Судалгаа шинжилгээ болон төлөвлөгөөг хэрэгжүүлэх бусад үйл ажиллагаанд гадаад, дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлэх;

е/ Жил бүрийн төсөвт дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг тусгаж ажиллах;

ё/ Аймгийн Засаг даргын сумын Засаг даргатай байгуулдаг хамтран ажиллах гэрээнд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний холбогдох арга хэмжээг тусган хэрэгжүүлэх;

ж/ Дэд хөтөлбөрийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх;

**3.4. САНХҮҮЖИЛТ:** дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүрийн төсөвт тусгаж, дараах эх үүсвэрүүдээс санхүүжүүлнэ. Үүнд:

а/ Улс, орон нутгийн төсөв

б/ Хог хаягдлын үйлчилгээний хураамж

в/ Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардал



г/Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө  
д/ Аж ахуйн нэгж, байгууллагаас гаргах хөрөнгө  
е/Бусад эх үүсвэр орно.

### **ДӨРӨВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

4.1. Дэд хөтөлбөрийн 2.2.1-д заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 4.1.1. Хог хаягдлын зохистой менежментийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;
- 4.1.2. Хог хаягдлын тооллого, судалгаа хийж, хог хаягдлын мэдээллийн сан үүсгэх;
- 4.1.3. Хог хаягдлын менежментийн тогтвортой санхүүжилтийн орчинбий болгох;
- 4.1.4. Хог хаягдлын менежментэд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах;
- 4.1.5. Хог хаягдлын хяналтыг сайжруулж, иргэн, аж ахуйн нэгж, багууллагын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх;

4.2. Дэд хөтөлбөрийн 2.2.2-т заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 4.2.1. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, татан зайлуулах машин механизмыг хүртээмжтэй болгох
- 4.2.2. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, татан зайлуулах үйл ажиллагааг хялбарчлах, боловсронгуй болгох арга хэмжээ авах
- 4.2.3. Төв суурин газруудын төвлөрсөн хогийн цэгийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх, шинээр байгуулах, өргөтгөх;

4.3. Хөтөлбөрийн 2.2.3-д заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 4.3.1. Дахин боловсруулах хог хаягдлыг ангилан ялгаж хэвших арга хэмжээ авах;
- 4.3.2. Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр, цех байгуулах;
- 4.3.3. Дахин боловсруулах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, төвлөрүүлэх цогц арга хэмжээ авах;

4.4. Хөтөлбөрийн 2.2.4-д заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 4.4.1. Аюултай хог хаягдал, хөрс, усны бохирдлын тооллого, судалгаа хийж, мэдээллийн сан үүсгэн, хяналт, шинжилгээ, судалгаа хийхэд шаардлагатай техник, багаж хэрэгслийн хангалтыг сайжруулах;
- 4.4.2. Хүн эмнэлэг болон мал эмнэлгийн аюултай хог хаягдлыг хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд халгүй аргаар зайлуулах, бохирдсон хөрс, усыг саармагжуулах, халдваргүйжүүлэх, цэвэршүүлэх арга хэмжээ авах;

4.5. Хөтөлбөрийн 2.2.5-д заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 4.5.1. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн хог хаягдлыг бууруулах;
- 4.5.2. Хуримтлагдсан хур хог хаягдлыг бууруулж, ашиглагдахгүй байгаа хогийн цэгүүдийг байгальд ээлтэй аргаар дарж булаах;

4.6. Хөтөлбөрийн 2.2.6-д заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 4.6.1. Хог хаягдлыг бууруулах, амьдрах орчноо цэвэрлэж тохижуулах чиглэлээр нийтийг хамарсан компанит ажлуудыг зохион байгуулах;

000

4.6.2. Хог хаягдлын чиглэлээр иргэд, олон нийтэд зөв дадал, зуршил төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны олон талт арга хэмжээ авах;

4.6.3. Аюултай хог хаягдлын талаар иргэдэд мэдлэг, мэдээлэл олгох сургалт, сурталчилгааг зохион байгуулах;

#### **ТАВ. ГАРАХ ҮР ДҮН, ТҮҮНИЙГ ТАЙЛАГНАХ**

5.1. Дэд хөтөлбөр хэрэгжсэнээр хог хаягдлын зохистой менежментийн эхлэл тавигдаж, хот суурин газарт эрүүл ахуйн шаардлага хангасан төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагаа жигдэрч, нийт хог хаягдлын 10-аас доошгүй хувийг эргүүлэн ашиглах, хог хаягдлын мэдээллийн сантай болж, аюултай хог хаягдал хуримтлагдахаас сэргийлэх нөхцөл бүрдсэн байна.

5.2. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, 2020 онд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.



**“ХОГГҮЙ ЦЭВЭР АЛТАЙ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Арга хэмжээ	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт		Санхүүгийн эх үүсвэр	Хэрэгжүүлэх хугацаа	Зохион байгуулагч	
			Хэмжих нэгж	Хүрэх үр дүн			Үндсэн	Хамтрагч
<b>Нэг. Хог хаягдлын эрх зүйн орчин, удирдлага зохион байгуулалт, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох зорилтын хүрээнд:</b>								
1	1.1.Хог хаягдлын зохистой менежментийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;	1.1.1.Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх журам баталж, мөрдүүлнэ	Журам батлагдсан байна.	Хог хаягдал бууруулах ажлын санхүүгийн эх үүсвэр тодорхой болно.	-	2017оны IV улирал	Аймгийн Засаг дарга БОАЖГ	Аймгийн ИТХ
2		1.1.2.Засгийн газраас батлагдсан аргачлалын дагуу хог хаягдлын нормативыг тогтоож, батлуулан мөрдүүлнэ	Норматив тогтоосон сумын тоо	18 сум тогтоож, мөрдүүлсэн байна	ОНТ	2017, 2020	Сумын Засаг дарга нар	БОАЖГ
3		1.1.3.Сумын хог хаягдлын нормативд үндэслэн тогтоосон аргачлалын дагуу тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоож, батлуулна	Үйлчилгээний хураамж шинэчилж баталсан сумын тоо	18 сум	-	2017, 2020	Сумын Засаг дарга нар	Сумын ИТХ, БОАЖГ
4		1.1.4.Хог хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, иргэнийг дэмжих, урамшуулах боломжийг судалж хэрэгжүүлнэ	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Орчны бохирдол буурна.	ОНТ, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр	2017-2018	Сумын Засаг дарга нар	Сумын ИТХ, БОАЖГ
5		1.1.5.Сумдын тохижилт үйлчилгээний нэгж, газруудын үйл ажиллагааны журам баталж мөрдүүлнэ	Журам батлагдаж, мөрдөж эхэлсэн байна.	Хог зайлуулах үйлчилгээ болон тохижилтын ажлын зохион байгуулалт сайжирна.	-	2017 IV улирал	Сумын Засаг дарга нар	Сумын ИТХ

142

6	1.1.6.Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдалд хяналт тавих, үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Уул уурхайн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлын менежмент сайжирна	-	2017, 2018, 2019, 2020	ХОХБТХ	Сумын Засаг дарга нар
7	1.1.7.Сангийн яамнаас боловсруулсан хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйл ажиллагааг дэмжих бодлогын хэрэгжилтийг хангах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Санхүүгийн эх үүсвэр нэмэгдэнэ	-	2017, 2018, 2019, 2020	СТСХ	Сумын Засаг дарга нар
8	1.1.8.Зам тээвэр, барилга, хот байгуулалтын барилгын хог хаягдлыг дахин - ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, дэмжлэг үзүүлэх, хяналт тавина	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын - хог хаягдлын менежмент сайжирна	-	2017, 2018, 2019, 2020	ГХБХБГ	Сумын Засаг дарга нар, АЗЗА ТӨХК, АТТ
9	1.1.9. Эрүүл мэндийн салбарын харьяа нэгж, байгууллагынхаа хог хаягдлын менежментийг хариуцаж хяналт тавин, үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, дэмжлэг үзүүлнэ	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Эрүүл мэндийн салбарын хог хаягдлын менежмент сайжирна	-	2017, 2018, 2019, 2020	ЭМГ	Сумын Засаг дарга нар
10	1.1.10. Боловсрол, соёл, урлагийн салбарын харьяа нэгж, байгууллагынхаа хог хаягдлын менежментийг хариуцаж хяналт тавин, үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, дэмжлэг үзүүлнэ	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Боловсрол, соёл, урлагийн салбарын хог хаягдлын менежмент сайжирна	-	2017, 2018, 2019, 2020	ГХБХБГ	Сумын Засаг дарга нар, АДБАЧ, ОНСМ
11	1.1.11.Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл	Үйл ажиллагааны	Эрчим хүчний салбарын хог	-	2017, 2018, 2019, 2020	Аймгийн ЭХЗСЗ	Сумын Засаг

2018

		ажиллагаанаас үүсэх хог хаягдалд хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;	хэрэгжилтээр	хаягдлын менежмент сайжирна				дарга нар, Алтай-Улиастай ЭХС ТӨХК, Мандал голомт ХХК
12	1.2. Хог хаягдлын тооллого, судалгаа хийж, хог хаягдлын мэдээллийн сан үүсгэх;	1.2.1. Хог хаягдлын анхан шатны тоо бүртгэл хөтлөнө	Журмын хугацаанд тоо бүртгэл хөтөлж, тайлагнасан байна	Хог хаягдлын мэдээллийн сан баяжигдана.	-	2017, 2018, 2019, 2020	Сумын Засаг дарга нар	Статистикийн хэлтэс, БОАЖГ
13		1.2.2. Хог хаягдлын дунд шатны тоо бүртгэл хөтлөнө			-	2017, 2018, 2019, 2020	Аймгийн Засаг дарга	Статистикийн хэлтэс, БОАЖГ
14	1.3. Хог хаягдлын менежментийн тогтвортой санхүүжилтийн орчин бий болгох;	1.3.1. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төсөвт бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авна	Үйлчилгээний хураамжийн төвлөрүүлэлтийн хэмжээгээр	Үйлчилгээний хураамжийг бүх сум 100 хувь төлөрүүлдэг болно.	-	2017-2018	Сумын Засаг дарга нар	Багийн Засаг дарга, Татварын хэлтэс
15		1.3.2. Жил бүрийн орон нутгийн төсөвт хог хаягдлыг бууруулахтай холбоотой ажлын төсвийг тусган батлуулж ажиллана	Төсөв батлуулсан сумын тоогоор	Жил бүр 2-оос доошгүй ажлын төсөв батлуулсан байна.	-	2017, 2018, 2019, 2020	Сумын Засаг дарга нар	Аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга
16		1.3.3. Овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг сумын хог тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагаар хогийн цэгт төвлөрүүлэх арга хэмжээ авч, тээвэрлэх, устгах үйлчилгээний хөлсийг орон нутгийн орлогод төвлөрүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Эзэнгүй хог хаягдлын хэмжээ буурч, санхүүгийн эх үүсвэр нэмэгдэнэ.	-	2017, 2018, 2019, 2020	Аймгийн Засаг дарга	Сумын Засаг дарга нар, ГХБХБГ, БОАЖГ
17	1.4. Хог хаягдлын менежментэд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах;	1.4.1. Сумын төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагааг менежментийн гэрээгээр хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэхийг дэмжинэ	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хуулийн хэрэгжилт хангагдана.	-	2017 оны III улирал	Сумын Засаг дарга нар	Иргэн, аж ахуйн нэгж
18		1.4.2. Томоохон аж ахуйн нэгж,	Үйл	Эзэнгүй хог	-	2018 оны	Аймаг, сумын	Аж ахуйн



		байгууллагуудыг нийгмийн хариуцлагын хүрээнд хог хаягдал бууруулах ажилд татан оролцуулна	ажиллагааны хэрэгжилтээр	хаягдлын хэмжээ буурна.		II, III улирал	Засаг дарга нар	нэгж, байгууллага
19		1.4.3. Эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх арга хэмжээ авна	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хог хаягдлыг бууруулахад аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоо нэмэгдэнэ	-	2017, 2018, 2019, 2020	Аж ахуйн нэгж, байгууллага	Сум, багийн Засаг дарга нар, МХГ, ЦГ
20		1.4.4. Орчны 50 метр газрын хог, цас, мөсийг хамгийн сайн цэвэрлэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.	Жилд сурталчлах чиглэлээр хийсэн ажлын тоо	4	-	2017, 2018, 2019, 2020	Сумын Засаг дарга нар	БОАЖГ
21	1.5. Хог хаягдлын хяналтыг сайжруулж, иргэн, аж ахуйн нэгж, багууллагын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх;	1.5.1. Улсын болон орон нутгийн чанартай авто зам, замын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавина	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Зам дагуух хог хаягдал буурна	-	2017, 2018, 2019, 2020	Аймгийн АТТ	АЗЗА ТӨХК
22		1.5.2. Хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилга гаргах, зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус иргэдийн бүлэг байгуулж ажиллуулна	Байгуулагдсан бүлгийн тоо	5-аас доошгүй	-	2017-2020	Багийн Засаг дарга нар	Сумын Засаг дарга нар
23		1.5.3. Байгууллагын үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг	Ажилтан томилсон байгууллагын тоо	60-аас доошгүй	-	2017-2018	Аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, захирал нар	Сумын Засаг дарга нар

100

		хариуцах үүрэг бүхий ажилтан томилно						
24		1.5.4.Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих хог хаягдлын олон нийтийн байцаагчийг томилон ажиллуулна.	Томилогдсон олон хийтийн байцаагчийн тоо	Сум бүрт 3-аас доошгүй	Орон нутгийн төсөв	2017-2018	Сумын Засаг дарга нар	Багийн Засаг дарга нар
25		1.5.6.Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд төрийн бус байгууллага, иргэдийн бүлэг, иргэний тавих хяналтыг нэмэгдүүлнэ	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Олон нийтийн хяналт сайжирна	Орон нутгийн төсөв	2017, 2018, 2019, 2020	Сумын Засаг дарга нар	МХГ, ЦГ
26		1.5.7.Ил задгай хог хаяж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт тавих зорилгоор аймгийн төвийг камержуулна	Байрлуулсан камерын тоо	20-оос доошгүй	ОНТ, ОНХС	2018-2019	Есөнбулаг сумын Засаг дарга	БОАЖГ
27		1.5.8. Аж ахуйн нэгж, байгууллагуудын орчны 50 метрийн радиус доторх хог хаягдалд байнгын хяналт тавьж ажиллана	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Төв суурин газрын орчны бохирдол буурна	-	2017, 2018, 2019, 2020	Сум, багийн Засаг дарга нар	МХГ,ЦГ
28		1.5.9. Зориулалтын сав, цэгээс бусад газарт хог хаясан гэм буруутай этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэнэ	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Эзэнгүй хог хаягдлын хэмжээ буурна	-	2017, 2018, 2019, 2020	МХГ, ЦГ	Сум, багийн Засаг дарга нар
29		1.5.10.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагууд хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хуулийн хэрэгжилт хангагдана	-	2017, 2018, 2019, 2020	Аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, эрхлэгч, захирал нар	Сум, багийн Засаг дарга нар, МХГ, ЦГ
30		1.5.11. Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд байнга хяналт тавьж, хариуцлага тооцож ажиллана	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хуулийн хэрэгжилт хангагдана	-	2017, 2018, 2019, 2020	Сум, багийн Засаг дарга нар, МХГ, ЦГ	Иргэд, иргэний бүлэг, ТББ, олон нийтийн байцаагч
<b>Хоёр. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, зайлуулах үйл ажиллагааг сайжруулж, хогийн цэгүүдийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн тохижуулах цогц арга хэмжээ авах зорилтын хүрээнд:</b>								
31	2.1.Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх,	2.1.1.Алтай хотын хог тээврийн үйлчилгээнд	Нэмэгдсэн машин,	10-аас доошгүй	ОНТ, ОНХС,	2017, 2018, 2019, 2020	Аймаг, сумын Засаг дарга,	-

2020

	татан зайлуулах машин механизмыг хүртээмжтэй болгоно	шаардлагатай машин, техник хэрэгслийн хангалтыг шат дараатай нэмэгдүүлнэ.	техник хэрэгслийн тоо		Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр		Алтай хотын тохижилт үйлчилгээний газар	
32		2.1.2. Сумын хог тээврийн үйлчилгээнд шаардлагатай машин техник хэрэгслийн хангалтыг сайжруулна.	Ковштой болсон сумын тоо	18	ОНТ, ОНХС, Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр	2017, 2018, 2019, 2020	Аймаг, сумын Засаг дарга	Аймаг, сумын ИТХ
33	2.2. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, татан зайлуулах үйл ажиллагааг хялбарчлах, боловсронгуй болгох арга хэмжээ авах	2.2.1.Аймгийн төвийн хог хаягдлыг тээвэрлэх дэд бүтцийн зураглалыг гаргаж хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг энэ батлуулан мөрдөж ажиллана	Хуваарь батлагдаж, мөрдөгдөж хэвшсэн байна.	Хог тээврийн үйлчилгээ сайжирна	-	2017 оны III улирал	Есөнбулаг сумын Засаг дарга	ГХБХБГ, Алтай хотын тохижилт үйлчилгээний газар
34		2.2.2.Алтай хотын гэр хорооллын айл өрхийг нэг загварын хогийн савтай болгоно.	Хогийн савны тоо	2000 -аас доошгүй	ОНТ, ОНХС, Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр	2017, 2018, 2019, 2020	Аймаг, сумын Засаг дарга, Алтай хотын тохижилт үйлчилгээний газар	-
35		2.2.3. Хог хаягдлыг ачих үйлдлийг хялбаршуулах, автоматжуулах арга хэмжээ авна	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хог тээврийн үйл ажиллагаа сайжирна	ОНТ, ОНХС, Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр	2017, 2018, 2019, 2020	Сумын Засаг дарга нар	Алтай хотын тохижилт үйлчилгээний газар
36	2.3. Төв суурин газруудын төвлөрсөн хогийн цэгийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх, шинээр байгуулах, өргөтгөх;	2.3.1.Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгийг тохижуулах зураг, төсөв хийлгэж, тохижуулна	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Эрүүл ахуйн шаардлага хангасан шинэ хогийн цэгтэй болно.	УТ, ОНТ, Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр	2018-2019	Аймгийн Засаг дарга, Есөнбулаг сумын Засаг дарга	Алтай хотын тохижилт үйлчилгээний газар
37		2.3.2. Сумын төвийн хүн амын тоо, хог хаягдлын хэмжээ, цаашдын хандлагатай уялдуулан хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийг тохижуулах нэг загварын зураг төсөл боловсруулна	Зураг төсөв, хийлгэсэн сумын тоо	17	-	2018оны II, III улирал	Аймаг, сумын Засаг дарга нар	Мэргэжлийн байгууллага
38		2.3.3.Сумдын төвлөрсөн хогийн цэгийг батлагдсан /боловсруулсан/ зураг төсвийн	Хогийн цэг тохижуулсан сумын тоо	18	УТ, ОНТ, ОНХС, Төсөл,	2019 оны II, III улирал	Сумын Засаг дарга нар	-

600



		дагуу тохижуулна			хөтөлбөрийн хөрөнгөөр			
39		2.3.4.Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэнэ	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл буурна.	ОНТ, төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр	2018 оны I-Иулирал	Алтай хотын тохижилт үйлчилгээний газар	Есөнбулаг сумын Засаг дарга
40		2.3.5.Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгийг ландфиллийн аргаар дарж булаах ажлыг эхлүүлнэ	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хогийн цэгийн талбай багасна	УТ, ОНТ, Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр	2018-2019	Алтай хотын тохижилт үйлчилгээний газар	Есөнбулаг сумын Засаг дарга, мэргэжлийн байгуулаг а
<b>Гурав. Хог хаягдлыг дахин боловсруулж, хоёрдогч бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар хаягдлын хэмжээг бууруулах зорилтын хүрээнд:</b>								
41	3.1.Дахин боловсруулах хог хаягдлыг ангилан ялгаж хэвших арга хэмжээ авах;	3.3.1.Сумдын айл өрхүүд, аж ахуйн нэгж, байгууллагууд, үйлчилгээний газруудыг ангилан ялгах хогийн савтай болгоно	Хогийн савтай болсон өрхийн тоо	3000-аас доошгүй өрх хогийн савтай болсон байна.	ОНТ, ОНХС, төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр	2018, 2019	Аймаг, сумын Засаг дарга нар	Багийн Засаг дарга нар
42		3.3.2.Сумдыг зохион байгуулалтанд оруулж, хог хаягдлыг ангилан ялгах арга хэмжээ авна	Ангилан ялгасан хог хаягдлын хэмжээ	Жилд гарах хог хаягдлын 5-аас доошгүй хувийг ангилан ялгасан байна.	-	2018 оны II-IVулирал	Сум, багийн Засаг дарга нар	МХГ, ЦГ, БОАЖГ
43	3.2.Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр, цех байгуулах;	3.2.1.Дахин боловсруулж болох хог хаягдлын нарийвчилсан судалгаа хийж, судалгааны дүнд суурилсан хог хаягдал дахин боловсруулах цех байгуулна	Есөнбулаг сумд 1 цех байгуулагдана	Жилд гарах хог хаягдлын 5-аас доошгүй хувийг дахин боловсруулна.	УТ, ОНТ, төсөл хөтөлбөрийн хөрөнгө	2017 оны II улиралаас 2018 оны III улирал	Аймгийн Засаг дарга, БОАЖГ	Сумын Засаг дарга нар
44	3.3. Дахин боловсруулах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, төвлөрүүлэх цогц арга хэмжээ авах;	3.3.1.Сумдын дунд хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах чиглэлээр болзолт уралдаан, аяныг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хог хаягдлын ангилан ялгах үйл ажиллагаа жигдэрнэ	Улс, ОНТ, ОНХС, төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр	2018 оны II улирал	Аймгийн Засаг дарга, БОАЖГ	Алтай хотын тохижилт үйлчилгээний газар
45		3.3.2.Хог тээвэрлэлтийн тогтолцоонд ангилсан хог хаягдлыг гарагийн хуваарьтай тээврийн тогтолцоог	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Гарагийн хуваарьтай хог тээвэрлэж эхэлсэн байна.	-	2018 II улирал	Сумын Засаг дарга нар	Алтай хотын тохижилт үйлчилгээн

		нэвтрүүлнэ.							ий газар, хог тээврийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж
<b>Дөрөв. Аюултай хог хаягдлыг байгаль орчинд хал багатайгаар зайлуулж, аюултай хаягдал хуримтлагдахаас сэргийлэх зорилтын хүрээнд:</b>									
46	4.1. Аюултай хог хаягдал, хөрс, усны бохирдлын тооллого, судалгаа хийж, мэдээллийн сан үүсгэн, хяналт, шинжилгээ, судалгаа хийхэд шаардлагатай техник, багаж хэрэгслийн хангалтыг сайжруулах;	4.1.1.Бохирдлын судалгаа хийх иж бүрэн автомат багажтай болно.	3000 бодисын агууламж тодорхойлох хүчин чадалтай DELTA XAONNI багажтай болно.	Хөрс, усны бохирдол тодорхойлж, мэдээллийн сан үүсгэх, бохирдолд хяналт тавих нөхцөл бүрдэнэ.	ОНТ, ОНХС	2018 оны I-II улирал	Аймгийн Засаг дарга, БОАЖГ	Аймгийн ИТХ	
47		4.1.2.Химийн бодисын сав баглаа боодол болон устгах шаардлагатай химийн бодисын судалгаа хийнэ.	Судалгаа хийсэн сумын тоо	18	-	2018-2019	Сумын Засаг дарга нар	БОАЖГ	
48		4.1.3.Иапоёёёаээр бохирдсон газрын судалгаа хийнэ.	Судалгаа хийсэн сумын тоо	18	-	2017-2018	Сумын Засаг дарга нар	БОАЖГ, ХХААГ	
49		4.1.4.Аймгийн бохирдсон газрын мэдээллийн сан үүсгэнэ	Бохирдлын судалгаа хийсэн сумын тоо	18	-	2017 оны IV улирал	Сумын Засаг дарга нар	БОАЖГ	
50	4.2. Хүн эмнэлэг болон мал эмнэлэгийн аюултай хог хаягдлыг хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд халгүй аргаар зайлуулах, бохирдсон хөрс, усыг саармагжүүлэх, халдваргүйжүүлэх,	4.2.1.Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, дэмжлэг үзүүлнэ	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Эрүүл мэндийн салбарын аюултай хог хаягдлын менежмент сайжирна	УТ, ОНТ	2017-2020	ЭМГ	Сумын Засаг дарга нар	

51	цэвэршүүлэх арга хэмжээ авах;	4.2.2.Сумдад эмнэлгийн аюултай хог хаягдлын цэг байгуулж тохижуулах	Байгуулагдсан цэгийн тоо	18	УТ, ОНТ, ОНХС, төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр	2018-2019	Сумын Засаг дарга нар, ЭМГ	-
52		4.2.3.Халдварт өвчний улмаас үхсэн мал, амьтны сэг зэмийг байгаль орчин болон хүний эрүүл мэндэд халгүй арга технологиор устгана	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Сөрөг нөлөөлөл буурна.	-	Тухай бүр	Сумын Засаг дарга нар ЗӨСТ, ХХААГ	МХГ, ОБГ
53		4.2.4.Сармагжуулах, цэвэршүүлэх шаардлагатай газрыг төсөл хөтөлбөрт хамруулна	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Сөрөг нөлөөлөл буурна.	Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр	2018-2019	Аймаг, сумын Засаг дарга БОАЖГ	МХГ

**Тав.Эзэнгүй хог хаягдлын хэмжээг бууруулах ажлын хүрээнд:**

54	5.1. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн хог хаягдлыг бууруулах;	5.1.1.Нийтийг хамарсан баяр, ёслол, наадам болон бүх төрлийн үйл ажиллагааны үеэр хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, хог хаягдал бууруулах арга хэмжээ авна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Эзэнгүй хог хаягдлын хэмжээ буурна	ОНТ	2017, 2018, 2019, 2020	Сум, багийн Засаг дарга нар	МХГ, ЦГ
55		5.1.2.Нийтийн эзэмшлийн гудамж талбайд шаардлага хангасан хогийн савыг хангалттай хэмжээгээр байршуулна	Шинээр байршуулсан хогийн савны тоо	Сум бүрт хогийн савны тоо одоо байгаагаас нэмэгдсэн байна.	ОНТ, төсөл хөтөлбөрийн хөрөнгө	2017-2018	Сумын Засаг дарга нар	Алтай хотын тохижилт үйлчилгээний газар
56		5.1.3.Аймгийн төвийн хогийн бункер байрших газрыг цементлэх, бетондох арга хэмжээ авна	Цементэлж, бетондсон газрын тоо	10-аас доошгүй	ОНТ, төсөл хөтөлбөрийн хөрөнгө	2018-2019	Есөнбулаг сумын Засаг дарга	Алтай хотын тохижилт үйлчилгээний газар
57		5.1.4.Төв суурин газруудад бүх нийтийн цэвэрлэгээг тогтмол зохион байгуулна	Нийтийн цэвэрлэгээ зохион байгуулсан тоо	Сум бүр жилд 4-өөс доошгүй удаа	ОНТ, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө	2017, 2018, 2019, 2020	Сумын Засаг дарга нар	-
58	5.2. Хуримтлагдсан	5.2.1.Ил задгай хуримтлагдсан	Хур хог	Есөнбулаг,	Орон нутаг,	2018-2019	Сумын Засаг	ХХҮХэлтэс

202



	хур хог хаягдлыг бууруулж, ашиглагдахгүй байгаа хогийн цэгүүдийг байгальд эзлтэй аргаар дарж булах;	хур хог хаягдлыг цэвэрлэх, эргэж үүсгэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ	хаягдлаа цэвэрлэсэн сумын тоо	Бигэр, Дэлгэр, Хөхморьт, Цээл сумууд хур хог хаягдлаа цэвэрлэсэн байна.	ОНХС, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө		дарга нар	
59		5.2.2. Ашиглагдахгүй байгаа хогийн цэгүүдийг дарж булах, утсгах арга хэмжээ авна	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хур хог хаягдлын хэмжээ буурна	ОНТ, ОНХС, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө	2018	Сумын Засаг дарга нар	ХХҮХэлтэс
60		5.2.3. Ил задгай тогтмол үүсдэг үүсмэл хогийн цэгүүдийг дахин үүсгүүлэхгүй байх арга хэмжээ авна	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Тогтмол үүсдэг хогийн цэггүй болно.	ОНТ, ОНХС, төсөл хөтөлбөрийн хөрөнгө	2018-2019	Сумын Засаг дарга нар	-
<b>Зургаа. Хүн амд ногоон хэрэглээний соёл, амьдрах орчны эрүүл ахуйн зөв дадлыг төлөвшүүлэх арга хэмжээ авах зорилтын хүрээнд:</b>								
61	6.1. Хог хаягдлыг бууруулах, амьдрах орчноо цэвэрлэж тохижуулах чиглэлээр нийтийг хамарсан компани ажлуудыг зохион байгуулах;	6.1.1. Хоггүй орчин бүрдүүлэх, гялгар уут, торноос татгалзах, даавуун уут, тор хэрэглэх аян зохион байгуулна	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Жилд 1-2 аян зохион байгуулна.	ОНТ, төсөл хөтөлбөрийн хөрөнгө	2018	Аймаг, сумын Засаг дарга нар, БОАЖГ	МХГ, ЭМГ
62		6.1.2. Хог хаягдлыг ил задгай хаях явдалтай тэмцэх аян зохион байгуулна	Зохион байгуулсан аяны тоо	Жилд бүр зохион байгуулна.	ОНТ, төсөл хөтөлбөрийн хөрөнгө	2018, 2019, 2020	Аймаг, сумын Засаг дарга, МХГ, ЦГ	БОАЖГ
63		6.1.3. Хоггүй сум аян зохион байгуулна	Сумын тоо	18	ОНТ, төсөл хөтөлбөрийн хөрөнгө	2018, 2019	Аймаг, сумын Засаг дарга, БОАЖГ	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага
64	6.2. Хог хаягдлын чиглэлээр иргэд, олон нийтэд зөв дадал, зуршил төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны олон талт арга хэмжээ авах;	6.2.1. Хог хаягдлаас үүдэлтэй байгаль орчны доройтол түүний сөрөг үр дагавар болон хог хаягдлыг ангилан ялгах, зориулалтын сав, цэгт хаях зөв ухамсар сэтгэлгээг иргэдэд төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулна.	Сургалт, сурталчилгаанд хамруулсан хүний тоо	Жилд 1000-аас доошгүй хүүхэд, 1500-аас доошгүй насанд хүрэгчид	ОНТ, төсөл хөтөлбөрийн хөрөнгө	2017, 2018, 2019, 2020	Бүх шатны Засаг дарга нар	Багийн Засаг дарга нар, БСУГ
65		6.2.2. Хог хаягдлын чиглэлээр зөв ухамсар, дадал бий болгоход хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй байнга хамтран	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Иргэдэд мэдлэг мэдээлэл олгоно.	ОНТ, төсөл хөтөлбөрийн хөрөнгө	2017, 2018, 2019, 2020	Бүх шатны Засаг дарга нар, БОАЖГ	Багийн Засаг дарга нар, МХГ

208

		ажиллана						
66		6.2.3.Байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэн, дадал зуршлыг хэвшүүлнэ	Сургалт хийсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо	50-аас доошгүй	Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө	2017-2020	Аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, захирал нар	Сумын Засаг дарга нар
67	6.3. Аюултай хог хаягдлын талаар иргэдэд мэдлэг, мэдээлэл олгох сургалт, сурталчилгааг зохион байгуулах;	6.3.1.Аюултай хог хаягдлын хор уршиг, түүнийг хэрхэн хадгалах, устгах талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулна.	Сургалт зохион байгуулсан байна.	Сумын удирдлагууд, иргэдийн мэдлэг дээшилнэ.	ОНТ, төсөл хөтөлбөрийн хөрөнгө	2017, 2018, 2019, 2020	БОАЖГ, МХГ	Насан туршийн боловсролын төв, Эрүүл мэндийн газар